**ТӨВ АЙМАГ**
**ЖАРГАЛАНТ СУМЫН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 02 өдөр | Дугаар 24 | Жаргалант сум

Урианы жилийн ажлын төлөвлөгөө
батлаж, хороо байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Хүртээмжтэй чанартай төрийн үйлчилгээ 2020 оны урианы жилийн ажлыг зохион байгуулах хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Хорооны дарга:

В.Болортуяа -ЗДТГ-ын дарга

Нарийн бичгийн дарга:

Б.Баярмаа -ХЭЗМ

Гишүүдэд:

Л.Идэр 0-ЕБС-ийн захирал
С.Дэлгэрмаа -ЭМТ-ийн эрхлэгч
О.Ганчимэг -СТ-ийн эрхлэгч
В.Отгонжаргал -Төвийн цэцэрлэгийн эрхлэгч
Ц.Лхагвасүрэн -Өгөөмөр цэцэрлэгийн эрхлэгч
Н.Тэгшжаргал -Баянбулаг цэцэрлэгийн эрхлэгч
Д.Пүрэвсүрэн -Дэжид цэцэрлэгийн эрхлэгчийг түр орлон гүйцэтгэгч

2. Хүртээмжтэй чанартай төрийн үйлчилгээ 2020 оны урианы жилийн ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Урианы жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, чанартай зохион байгуулахыг хорооны дарга /В.Болортуяа/ болон нийт төрийн албан хаагчдад даалгасугай.

ДАРГА Д.УРАНЧИМЭГ

ХТУ3161 1420030008 3874737

D:\My_doc\TOGTOOL
200512

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн
2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 24 дүгээр
тогтоолын хавсралт

# ХҮРТЭЭМЖТЭЙ ЧАНАРТАЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
# 2020 ОНЫ УРИАНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| д/д | Арга хэмжээ | Хугацаа | Хөрөнгийн эх үүсвэр | Суурь үзүүлэлт | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | Хариуцах байгууллага албан тушаалтан | Хамтран зохион байгуулах байгууллага албан тушаалтан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1: Цахим засаллыг өргөжүүлэх замаар иргэдийн төрөөс авах, үйлчилгээний боломжийг нэмэгдүүлж, нөхцлийг хялбаршуулан төрийн байгууллагын шуурхай ил тод байдлыг хангана.** | | | | | | | | |
| 1 | Хур системийг нэвтрүүлж иргэн хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэнэ | Жилдээ | УТ, ОНТ | Нэг цэгээр иргэдэд үйлчилж байна. | Хур систем нэвтэрсэн байдал | Хур систем нэвтэрсэн байна. | Засаг дарга, бүх төрийн байгууллага, ОНИМТ-ийн ажилтан | Төв аймгийн Засаг даргын Тамгын газар |
| 2 | Төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг хангуулж, цахим хуудасны баяжилтанд шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт тавьж ажиллана | Улирал бүр | | Цахим хуудасны баяжилт 40%тай. | Цахим хуудасны баяжилт хандалтаар | Төрийн байгууллагуудын цахим хуудасны баяжилт 70%д хүрсэн байна. | ОНИМТ-ийн ажилтан ЗДТГ-ын дарга | Байгууллагууд |
| 3 | Гамшгаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, цаг үеийн мэдээ, мэдээллийг иргэд байгууллагад цахим, сүлжээ олон нийтийн харилцааны хэрэгсэл ашиглан түргэн шуурхай хүргэнэ. | Тухай бүр | | Цахим сүлжээгээр иргэдэд үзүүлсэн үйлчилгээ 70%тай. | Масс мсж түгээлтийн өсөлт | Учирч болох эрсдэл буурсан байна. | ЗДТГ-ын дарга ОНИМТ | Цаг уурын өртөө |
| 4 | Төрийн албан хэрэг хөтлөлтийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлнэ | Жилдээ | | Цахимд шилжүүлэх ажил 30%тай байна. | Цахимд оруулсан баримтын хувиар | Албан хэрэг хөтлөлтийг 50%д хүргэнэ. | АБХЭ | ЭМТ, СӨББ, ЕБС-ийн бичиг хэргийн ажилтнууд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Иргэдээс архивын лавлагааг онлайнаар авах нөхцлийг бүрдүүлнэ. | Жилдээ | | 2019 онд гэр бүлийн 121, иргэний үнэмлэхний 143 лавлагааг олгосон. | Ирүүлсэн хүсэлтийн тоогоор | Хүсэлтийг 100% хэрэгжүүлсэн байна. | Улсын бүртгэгч | Улсын бүртгэлийн хэлтэс |
| 6 | Малын эрүүл мэндийн нэгдсэн системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ. | жилдээ | | 2019 онд системд нэвтрэх сургалтанд хамрагдсан. | Системд нэвтрүүлсэн малын тоогоор | Системд нэвтэрснээр мал хулгайлах гэмт хэргээс у/сэргийлэх,малын гоц халдварт болон халдварт өвчнөөс у/сэргийлэх хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах ажилд эерэг нөлөөлнө | МЭҮТ | Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар |
| 7 | Иргэдэд цаг хугацаа байршил харгалзахгүй үйлчилгээ авах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн газрын цахим биржийг хөгжүүлнэ. | Жилдээ | | 2019 онд 4 байршилд дуудлага худалдаа зохион байгуулсан. | Газар эзэмшүүлэх дуудлага худалдааны тоо | 2020 онд 21 байршилд дуудлага худалдаа зохион байгуулна. | ЗДО Газрын даамал | ГХБХБГ |
| 8 | Газрын мэдээллийн Ленд менежер программыг цахим хэлбэрт шилжүүлж ашиглалтыг сайжруулна. | Жилдээ | | ГЗБайгуулалтын төлөвлөгөөг цахим хэлбэрт оруулсан | | ГЗБТөлөвлөгөөг цахимд оруулснаар иргэд, олон нийт хяналт тавих боломж нээгдэнэ. | Газрын даамал | Төв аймгийн ГХБХБГ |
| 8 | Иргэн, ААН-ийн газрын төлбөр ногдуулалтыг цахим хэлбэрт шилжүүлж татварын орлогыг нэмэгдүүлнэ. | Жилдээ | | Газрын мэдээллийн санд бүртгэлтэй 389 газар эзэмшигч, 2 ашиглагч байна. | Гүйцэтгэлийн хувиар | Иргэн, ААН, газрын төлбөр, татварын үйлчилгээг цахимаар авдаг болно.татварын орлого нэмэгдэнэ. | ТУБ | Татварын хэлтэс |
| 9 | Төсөвт байгууллагын худалдан авах үйл ажиллагаа цахимаар | Жилдээ | | Цахим тендер зарлаж хэвшсэн. | Цахим тендер зарласан тоо, | Ил тод байдал хангагдана. | ЗДО | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулна. | | | | гүйцэтгэлийн хувиар | | | |
| 10 | Цаг хугацаа орон зайнаас үл хамааран төрийн үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлж цахим нийгмийн даатгалын үйлчилгээнд иргэд, даатгуулагчдыг хамруулна. | Жилдээ | | 2019 онд цахим гарын үсгээр 2 ААН тайлангаа өгсөн. | Гүйцэтгэлийн хувиар | 2020 онд 4 ААН-ийг хамруулна. | НДУБ нар | Нийгмийн даатгалын хэлтэс |
| 11 | Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг цахимжуулж, иргэдийн үйлчилгээ авах нөхцлийг хангана. | Жилдээ | | 2019 онд 113 өрх хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлж байна. | Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг цахимаар авч байгаа өрхийн тоогоор | Үйлчилгээний түргэн шуурхай байдал хангагдана. | ХХҮМ | ХХҮГ |
| 12 | Ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчдийн баримт бичгийг цахим болгох замаар үйлчилгээний шуурхай байдлыг хангана. | Жилдээ | | 2019 онд 9-р анги-82<br>12-р анги-64<br>нийт 146 хүүхдийн мэдээллийг цахим хэлбэрт оруулсан. | Баримт бичгийг цахимаар хүлээн авсан төгсөгчдийн тоогоор | Сургууль төгсөгчдийн мэдээллийн сан бий болно. | ЕБС | |
| **Зорилт 2: Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх замаар үйлчилгээний чанарт ахиц гарган иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ** | | | | | | | | |
| 1 | Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 улсын стандарт нэвтрүүлэх бэлтгэл хангуулна. | Жилдээ | ОНТ нийгмийн хариуцлагын гэрээ | -2019 онд нийгмийн даатгалын салбарт ISO 9001:2015 улсын стандарт нэвтрүүлсэн. | 5s зарчмыг нэвтрүүлнэ. | Үйлчилгээний чанарт ахиц гарна. | Засаг дарга<br><br>ЗДТГ-ын дарга | |
| 2 | ЕБС, СӨББ-уудад менежментийн 5s-ийн зарчмыг нэвтрүүлж, байгууллагын соёл, үйлчилгээний чанарт ахиц гаргана. | Жилдээ | | Суурь үзүүлэлт байхгүй | Нэвтрүүлсэн цэцэрлэгийн тоогоор | 5s зарчим нэвтрүүлснээр үйлчилгээний соёл, чанарт ахиц гарна. | ЕБС, СӨББ-ийн захирал, эрхлэгч нар | |
| **Зорилт 3: Төрийн байгууллага албан хаагчдын үйл ажиллагааны гүйцэтгэл, ёс зүйн байдлыг иргэдээр үнэлүүлэх ажлыг эхлүүлж, сахилга хариуцлагыг чангатган урамшуулал, хариуцлагыг тооцно.** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах батлах биелэлтийг дүгнэх ажлыг ил тод болгон цахим системд шилжүүлэх ажлын бэлтгэлийг хангана | Жилдээ | | 2019 онд 6 Төрийн жинхэнэ албан хаагч үр дүнгийн гэрээгээр ажилласан. | Цахим санд нэвтрүүлсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоогоор | ТАХ-дын гүйцэтгэлийн төлөвлөгөөг цахим хэлбэрт шилжүүлж дүгнэж хэвшинэ. | ЗДТГ-ын дарга | ТЗУХ |
| 2 | Төрийн албан хаагчдын иргэний үүргийн биелэлтийг хангуулж Багийн нь ИНХ-д тухай бүр тогтмол оролцуулна. | Тухай бүр | | 2019 онд БИНХ-д 11 Төрийн албан хаагч оролцсон байна. | БИНХуралда оролцсон албан хаагчдын тоогоор | ТАХ-дын иргэний үүргийн биелэлт хангагдана. | Бүх байгууллагын дарга, эрхлэгч нар | |
| 3 | Санхүү бүртгэлийн ажилтнуудын мэргэжлийн ёс зүй, сахилга батыг чанд сахиулж, мэдлэг чадвараа дээшлүүлэх замаар иргэд байгууллагуудад үзүүлэх үйлчилгээний шуурхай байдлыг хангана | Жилдээ | | 2019 онд 1 албан хаагчийг ёс зүйн хорооны хурлаар хэлэлцүүлж үүрэг өгсөн. | Санхүүгийн ажилтны ёс зүйн дүрэм, хэм хэмжээний хэрэгжилтийн хувь | Санхүү бүртгэлийн зөрчилгүй ажилласан байна. | Санхүү албаны дарга | |
| **Зорилт 4: Төрийн үйлчилгээг нэгдсэн болон явуулын хэлбэрээр иргэдэд хүргэж, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна.** | | | | | | | | |
| 1 | Багийн явуулын төвөөр зорилтод бүлгийн өрхөд хүрэх төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Жилдээ | | 2019 онд Эрүүл мэнд, урлаг, соёл, нийгмийн даатгал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиар иргэнд явуулын үйлчилгээ үзүүлсэн. | Үйлчилгээ авсан иргэдийн тоогоор | Иргэдийн тоог 10%-иар нэмэгдүүлнэ. | БЗД, ЭМТ, Соёлын төв | |
| 2 | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг иргэн бүрт аян зохион байгуулна. | Жилдээ | | 2019 онд иргэдийн 80% у/сэргийлэх үзлэгт хамрагдсан. | У/сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдийн тоогоор | У/сэргийлэх үзлэгийг 85%д хүргэнэ. | ЭМТ | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | ЕБС-ийн 1-5 дугаар ангийн сурагчдыг шим тэжээллэг, аюулгүй, халуун хоолны үйлчилгээнд тэгш хамруулах боломж бүрдүүлж "Үдийн хоол" хөтөлбөрт шилжүүлэх ажлыг эхлүүлнэ. | Жилдээ | Улсын, орон нутгийн төсөв | 2019 онд 7 хоногт 2 удаа үдийн хоол хүүхдүүдэд өгч хэвшсэн. | Тоног төхөөрөмжөөр хангагдсан байдал | Тоног төхөөрөмжийн хагалтыг нэмэгдүүлнэ. | ЕБС | |
| 4 | Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн сургалт, сурталчилгааг эрчимжүүлж, нийгмийн даатгалд хамрагдалтын хувийг нэмэгдүүлнэ. | Жилдээ | | 2019 онд давхардсан тоогоор 2190 иргэнд сургалт сурталчилгаа хийгдэж 480 иргэн сайн дурын даатгалд хамрагдсан. | Сургалт сурталчилгааны давтамж | Сургалт сурталчилгаа хийгдэж, нийгмийн даатгалд хамрагдалтын хувь өссөн байна. 2020 онд 500 иргэнийг хамруулна. | НДУБ | БЗД |
| 5 | Хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэхэд чиглэсэн дугуйлангийн чанар хүртээмж тоог нэмэгдүүлнэ | Жилдээ | | 2019 онд ЕБС-ийн 30 төрлийн дугуйлан, секцэнд 1212 хүүхэд, СӨББ-д 8-10 төрлийн дугуйланд 451 хүүхэд хамрагдсан. | Дугуйлангийн тоо, хамрагдах хүүхдийн тоо | Дугуйлан секцэнд хамрагдалтын өссөн дүнгээр | ЕБС, СӨББ | |
| 6 | Нутгийн удирдлагын байгууллагаас гаргаж буй бодлогын баримт бичиг, төсөв, хөрөнгө оруулалтын асуудлыг төслийн шатанд нь хэлэлцүүлэн сонсох үйл ажиллагаа явуулах саналыг шийдвэрт тусгах | Жилдээ | | Сонсох ажиллагаа хийгдээгүй | Шийдвэрийн төслийг хэлэлцүүлсэн сонсох ажиллагааны тоо,хамрагдсан иргэдийн тоо | Нийт шийдвэрийн 20%д сонсох ажиллагааг хийсэн байна. | ХЭЗМ | ТАХ-д, байгууллагууд |
| 7 | Хүртээмжтэй чанартай төрийн үйлчилгээний жилийн нээлтийг төрийн байгууллагуудын | 1-р улирал | | 2019 онд урианы жилийн нээлтийг сумын | Нээлтэнд хамрагдсан байгууллагуудын | Бүх байгууллагуудад уриан жилийн | ЗДТГ-ын дарга | Бүх байгууллагууд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээнд зохион байгуулах | | | соёлын төвд зохион байгуулсан. | тоо, оролцсон иргэдийн тоогоор | нээлтийг зохион байгуулсан байна. | | |
| **Зорилт 5: Төрийн үйлчилгээний таатай орчин бүрдүүлж, албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах замаар бүтээмжийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | |
| 1 | Төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж чадавхижуулах хөтөлбөр, Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | Жилдээ | | 2019 онд төлөвлөгөөний хэрэгжилт 80% | Төлөвлөгөөний хэрэгжилтээр | Төлөвлөгөөний хэрэгжилтийг 85 хувьд хүргэнэ. | Байгууллагын дарга, эрхлэгч нар | |
| 2 | Баг-97 төслийн хүрээнд хэсгийн ахлагчийн орон тоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана. | Жилдээ | | 2019 онд 7 эрх зүйн хөтөчийг урамшуулан ажиллуулж байна. | Шийдвэрлэсэн орон тооны тоогоор | 2 хэсгийн ухуулагчийг орон тооны болгосон байна. | Засаг дарга | СТСХ |

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:
ЗДТГ-ЫН ДАРГА В.БОЛОРТУЯА